

“Айтүүлс” ХК-ийн 2023 оны Засаглалын үнэлгээний тайлан

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Тийм	Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Тийм	Хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг, ялангуяа хараат бус гишүүдийг олон нийтээс нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, Нэр дэвшүүлэх хороо хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч ХЭХурлаар сонгож ажилладаг. Эдгээрийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг ч 2023 оны дөрөвдүгээр улиралд багтаан “Нэр дэвшүүлэх журам”, залгамж халааны бодлогыг албан ёсоор батлуулахаар төлөвлөж байна.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсанд байршуулна.</i>	-	ТУЗ-ийн гишүүдийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг ХЭХурал дээр танилцуулдаг, 2023 онд жилийн үйл ажиллагааны тайланд мэдээллийг бүрэн тусгаж, цахим хуудсанд байршуулж ажиллана.	1	50%
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Тийм	Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг. Компанийн залгамж халааны бодлогын бичиг баримтын төслийг боловсруулсан ба 2023 оны 3-р улиралд албажуулахаар ажиллаж байна.	2	100%
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Тийм	ТУЗ-ийн Дарга шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдэд мэдээ мэдээлэл өгч, чиглүүлэх уулзалт зохион байгуулдаг.	2	100%

6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Тийм	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зохицуулсан.	2	100%
ДҮН				11	91.7%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Тийм	Хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс доошгүй хувь нь хараат бус гишүүн бөгөөд хараат бус гишүүдийг олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулалт явуулан анкет хүлээн авч, Нэр дэвшүүлэх хороо хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч ХЭХурлаар сонгож ажилладаг.	2	100%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Тийм	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд “Аудитын хороо”-ны чиг үүргийг журамласан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн ажилладаг.	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Тийм	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд “Цалин урамшууллын хороо”-ны чиг үүргийг журамласан.	2	100%
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Тийм	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд “Нэр дэвшүүлэх хороо”-ны чиг үүргийг журамласан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн ажилладаг.	2	100%
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	Тийм	Компанийн тухай хуульд заасан хороодоос гадна “Бизнес хөгжлийн хороо”, “Мэдээллийн аюулгүй байдлын хороо”-г байгуулан тус хороодын чиг үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусган ажиллаж байна.	2	100%
ДҮН				10	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					

12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	-	Компани нь СЗХ болон МХБ-ийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг чанд хэрэгжүүлэн ажилладаг ба 2023 оны 3-р улиралд багтаан дотооддоо “Мэдээллийн ил тод байдал, тайлагналлын журам” баталж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	1	50%
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Тийм	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг компанийн цахим хуудаст байршуулсан.	2	100%
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>	Тийм	Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан нь тус шаардлагыг хангасан.	2	100%
ДҮН				5	83.3%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	<i>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортай харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Тийм	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд “Аудитын хороо”-ны чиг үүргийг тусгасан бөгөөд ТУЗ-ийн хагас жилийн ээлжит хурлаар хөндлөнгийн аудитын байгууллага сонгох ажлыг эхлүүлэн, нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлан ажилладаг.	2	100%
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Тийм	2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас эхлэн хөндлөнгийн аудиторын төлөөллийг хуралд оролцож байна.	2	100%
17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>	Тийм	Үйл ажиллагааны тайланг жил бүр гаргаж, МХБ-ийн болон компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулдаг, дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тайланд тусгах тал дээр анхаарч ажиллана. Дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийг зохицуулах “Дотоод аудитын журам”-ыг 2022 оны 12-р сард батлан мөрдөж байна, тус журмын дагуу жилд 2 удаа дотоод аудит хийж тайлан гаргах юм.	2	100%
ДҮН				6	100%

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Тийм	Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрсдлийг удирдах зорилгоор “Эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээг удирдах журам”-ыг 2022 оны 12-р сард батлан мөрдөж буй ба жилд 2 удаа эрсдлийн үнэлгээ хийж, шаардлагатай бол хариу арга хэмжээ авна. Түүнчлэн, компани нь 2022 оноос олон улсын ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо болон ISO/IEC 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартуудыг үе шаттай нэвтрүүлэн, 2023 оны 2 болон 5-р сард албан ёсоор сертификатуудаа гардан авсан.	2	100%
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>	-	Эрсдлийн хороог байгуулах, холбогдох бодлого журмыг баталж, үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд дэлгэрэнгүй мэдээлэ талаар судалж байна.	1	50%
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	-	2023 оны 4-р улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	1	50%
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Тийм	Комплайнсын бүтэц, хяналтыг 2022 оны 11-р сард баталсан “Байгууллагын төлөв байдал, сонирхогч талууд, хуулийн нийцлийн үнэлгээний журам”-аар зохицуулж байна.	2	100%
ДҮН				6	75%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Тийм	Цалин, урамшууллын төсвийг ХЭЭХ-аар батлуулдаг. 2023 оны ХЭХ-д цалин урамшууллын хэмжээ болон олгох хэлбэрийн талаар дэлгэрэнгүй танилцуулсан.	2	100%

23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Тийм	ТУЗ-ийн гишүүдийн хурлын идэвх, ирцэд үндэслэн олгодог. “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын журам”-тай.	2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	-	2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэлийн шалгуурыг тусгахаар ажиллаж байна.	1	50%
ДҮН				5	83.3%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Тийм	“Байгууллагын төлөв байдал, сонирхогч талууд, хуулийн нийцлийн үнэлгээний журам”-ын дагуу оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг жилд нэг удаа үнэлэн ажилладаг. ТУЗ нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах соёлыг төлөвшүүлэхээр ажиллаж байна.	2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	-	Оролцогч талуудтай хамтран ажиллах стратегийн талаар 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусгахаар төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна.	1	50%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Тийм	Оролцогч талуудтай буюу хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид болон бусад хамтрагчдад нээлттэй харилцах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломж бүхий цахим хуудастай бөгөөд өдөр тутам шалгаж, хариу арга хэмжээ авах хүний нөөц ажилладаг.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Тийм	Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-аар зохицуулдаг.	2	100%
ДҮН				7	87.5%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	-	“Ёс зүйн дүрэм”-ийн төслийг боловсруулсан ба ТУЗ-өөр 3-р улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.	1	50%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	-	2023 оны 4-р улиралд багтаан “Шүгэл үлээх” бодлого, бүтцийг тодорхой болгож, батлуулахаар ажиллаж байна.	1	50%

31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	-	Ёс зүйн дүрмийн төсөлд энэ талаар тусгасан.	1	50%
ДҮН				3	50%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	Тийм	Компанийн хагас жил болон жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаар цахим хуудсаар дамжуулан хүргэдэг.	2	100%
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	Тийм	Компанийн цахим хуудас дахь Айтүүлс хувьцаа хэсгээр дамжуулан мэдээлэл хүргэж, утсаар харилцдаг. “Байгууллагын төлөв байдал, сонирхогч талууд, хуулийн нийцлийн үнэлгээний журам”-ын дагуу хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ шаардлагыг жилд нэг удаа тодорхойлно. Үүний хүрээнд хөрөнгө оруулагчтай харилцах сувгийг сайжруулан ажиллана.	2	100%
34	<i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>	Тийм	Хуульд заасан эрхээ эдлэх боломжоор хууль, журмын дагуу ханган ажиллаж байна.	2	100%
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>	Тийм	Компанийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу эдгээр асуудлаар санал өгөх эрхээ хэрэгжүүлэх нөхцлөөр хангаж ажилладаг.	2	100%
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>	Тийм	Компанийн дүрмийн 12-р зүйлд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх талаар нарийвчлан тусгасан ба дүрмийн дагуу ажилладаг. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай мэдээллийг жил бүр тайланд тусган МХБ-ийн цахим хуудсанд нээлттэй байршуулдаг	2	100%
ДҮН				10	100%
НЭГДСЭН ДҮН				63	85.6%

- 3.2.1.авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
3.2.2.70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
3.2.3.50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
3.2.4.49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Санамж: Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ. Тухайлбал, “МХБ” ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна. Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно